



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 58-р хуралдааны тэмдэглэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох" судалгааны аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Ц.Эрдэнэсүрэн -Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Нарийн бичиг Г.Хишигдаваа -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Гишүүд

Ж.Өлзийжаргал - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Б.Очирдорж - Цагдаагийн газрын дарга

Я.Алтанхундага -Онцгой байдлын газрын дарга

Б.Энхтуяа -Статистикийн хэлтсийн дарга

Ц.Энхсайхан -Эрүүл мэндийн газрын дарга

Ч.Баяраа-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга


М.Туяацэцэг-Татварын хэлтсийн дарга

Хоёр. Судалгааны ажлын үйл явцыг удирдан зохион байгуулах, хамтран ажиллах, Өрхийн нэгдсэн жагсаалт, газрын зураг гаргах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ажлын хэсгээр хэлэлцүүлэн батлуулах, судалгааны ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, судалгааны ажлын үйл явцыг удирдан зохион байгуулах, хамтран ажиллах, өрхийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн жагсаалт, газрын зургийг үнэн зөв, хугацаанд нь чанартай гаргаж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200002007

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар
сарын 20-ны өдрийн 1/2 тоот
захирамжийн хавсралт



Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- | | |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч | Сумын Засаг дарга |
| Нарийн бичиг | Хөдөлмөр эрхлэлт, халамжийн
асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд | Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга
Багийн засаг дарга
Улсын бүртгэгч
Хэсгийн төлөөлөгч
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн
Татварын байцаагч
Нийгмийн даатгалын байцаагч |

